Олон Улсын Зуслангуудын Холбоо

2017 оны жилийн эцсийн тайлан

Олон Улсын Зуслангуудын Холбоо нь зуслангийн хөгжилд оруулсан хувь нэмэр, хүсэл тэмүүлэл, мэдлэг чадвар, итгэл үнэмшилээ бусадтай хуваалцах хүсэл сонирхолтой зуслан болон өсвөр залуу үеийг хөгжүүлэгч мэргэжилтнүүдийн дэлхийн хэмжээний холбоо юм.

Тус холбоо нь “гадна орчны хөтөлбөрүүдийг нэгтгэх” замаар өөрчлөлт шинэчлэлтийг авчрах хүсэл зорилгод үндэслэдэг билээ.

Зохион байгуулалтай зуслангийн үйл ажиллагааны талаархи олон улсын харилцан ойлголцлыг хөхүүлэн дэмжихийг хүссэн хэн бүхний өмнө Олон Улсын Зуслангуудын Холбооны үүд хаалга нээлттэй байдаг.

Агуулга

Ерөнхийлөгчийн мэндчилгээ 3

Гишүүнчлэл 4

ОУЗХ-ны Цахим сүлжээ 9

ОУЗХ-ны Их хурал 2017 10

Элч 12

ОУЗ-ийн захирлуудын сургалт 13

Санхүүжилт, Хөтөлбөрүүд 14

Судалгаа шинжилгээ 14

Ази дахь ОУЗХ 15

Санхүүгийн тайлан 16

Удирдлагын бүтэц 18

ОУЗХ-ны Удирдах зөвлөл 19

Олон Улсын Зуслангуудын Холбооны зорилго

Улс орны хувь хүмүүс, зуслангууд, албан байгууллагуудаас гадна орчинд зохион байгуулдаг хөтөлбөрүүдийн талаар мэдээ, мэдээлэл, туршлагыг харилцан солилцох үйл явцад дэмжлэг үзүүлэх,

Хоёр болон олон талт харилцан солилцоог дэмжих,

Зуслан болон гадна орчинд зохион байгуулдаг хөтөлбөрүүдийг зохион байгуулах замаар олон улсын болон дэлхий дахины ахуй амьдрал, манлайллын талаар ойлголтыг бий болгож улмаар байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах зорилгод түлхэц үзүүлэх, мөн

Бүс нутгийн болон үндэсний зуслангуудын холбоодын зохион байгуулалт, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Гүүр Бүтээгчид

Жон Жоргенсон

ОУЗХ-ны ерөнхийлөгч

2017 он бол Олон Улсын Зуслангуудын Холбооны хувьд томоохон эргэлт хийсэн жил байлаа. 2011 онд ОУЗХ-ны удирдлагын түвшинд томоохон өөрчлөлт хийснээс хойш тус холбооны удирдах зөвлөлд үлдэж тус холбоог өдий зэрэгт хүртэл хүчин зүтгэсэн үнэнч шударга, чадварлаг олон лидерүүд маань аль хэдийнээ 25 жилийг ардаа үдсэн байна. 30 дахь жилийн түүхээс эргэн харахад бид шинэ эрч хүчээр сэлбэгдэж, жинтэй ахиц дэвшил гарган үйл ажиллагаагаа амжилттай өргөжүүлэн тэлжээ. Хил хязгаарыг дамнан зуслангийн боловсролыг боловсронгуй болгож мэргэжлийн бодлогоор ханган зуслангийн холбоодын төлөвшилд дэмжлэг үзүүлэх гэсэн бидний зорилго хүчтэй хэвээр байна.

2011 онд Хонконг-д зохион байгуулсан Олон Улсын Зуслангуудын Их хурлаас хойш бид энэхүү хоёр томоохон өөрчлөлтийн гэрч болоод зогсохгүй эдгээр өөрчлөлтүүдийг бодитоор бий болгосон олон олон амжилтуудын эзэд болсон ОУЗХ-ны зуслангийн тэргүүнүүдийг чиглүүлж чаджээ. 2017 онд ОХУ-ын Сочи хотноо зохион байгуулагдсан Их Хурлын үеэр хийсэн тус эргэлт нь ОУЗХ-ны түүхэн дэх хамгийн том өөрчлөлт байсан гэдгийг цохон тэмдэглэх нь зүйтэй.

ОУЗХ болон түүний удирдах зөвлөлийн ахмад гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусснаар бусаддаа шинэ боломжуудыг олгож байна. Халаагаа өгч буй удирдах зөвлөлийн эдгээр гишүүдийг байнга санан дурсаж, энэ цаг үед тэдний оруулсан хувь нэмрийг хүлээн зөвшөөрч, ухамсарлах нь зүйтэй юм.

Билл Оакли

Өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд Билл нь дэлхийн зуслангийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулжээ. Тэрбээр АЗХ-оос (Австрали) амжилтын гараагаа эхлүүлж улмаар ОУЗХ-ны Ази-Номхон далайн бүс нутгийн төлөөлөгч, Их хурлын харилцаа холбоо хариуцсан захирал, Удирдах зөвлөлийн гишүүн болжээ. Билл Боукер Тэтгэлгийн Сан нь залуу мэргэжилтнүүдийг Их хурлын үйл ажиллагаанд оролцуулахад зориулагддаг бол Баттерфлай Сан (Эрвээхэй Сан) нь онцгой төслүүдэд нэн шаардлагатай санхүүгийн дэмжлэгийг үзүүлдэг. Тус холбоонд оруулсан түүний үнэтэй хувь нэмэр бол яахын аргагүй ОУЗХ-ны эдгээр хоёр сангийн Их хурлын тендер/зохион байгуулалт болон тэдгээрийн өсөлт/хөгжилтөд зориулсан дэлгэрэнгүй удирдамжийг боловсруулсан явдал юм.

Ази-Номхон далайн орнуудын зуслангуудын холбоо үүсэн байгуулагдсанаас хойш 14 жилийн хугацаанд Олон Улсын Зуслангуудын Холбооны Их хурлыг бүс нутгийн хэмжээнд 6 удаа зохион байгуулсан байна. Ази-Номхон далайн орнуудын зуслангуудын холбоогоор дамжуулан Азийн улс орнуудад зуслангийн боловсролыг олгосноор эдгээр орнууд нь зуслангийн боловсролыг боловсрол, солилцооны хөтөлбөр, судалгаа шинжилгээ мөн гэж үздэг болсон байна.

Дон Чили

Биллийн нэгэн адилаар Дон Чили бол АЗХ)өөр нэг Америкийн зуслангуудын холбоо-АЗХ(болон ОУЗХ-д олон жил ажилласан юм. Тэрбээр 1987 онд АЗХ-ны ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж эхлэснээс хойш 1997 онд ОХУ-ын Санкт Петербург хотод зохион байгуулагдсан Олон Улсын Зуслангуудын Их хуралд оролцож улмаар АНУ дахь ОУЗХ-г дэмжигчдийн нэг болсон юм. ОУЗХ-ны анхны элчээр ажилласан цагаас эхлэн Дон нь Хөтөлбөр Боловсруулалт хариуцсан Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Удирдах зөвлөлд ажиллах хугацаандаа тэрээр Батламж, Шагналын хөтөлбөрийг боловсронгуй болгож ОУЗХ-ны Олон Улсын Зуслангийн Захирлуудын Сургалтыг санаачлан зохион байгуулахад өөрийн хувь нэмрийг оруулж тус холбооны анхны Судалгаа, Шинжилгээний Хороог эмхлэн байгуулсан юм. Бизнес болон Удирдах зөвлөлийн менежментийн салбарт оруулсан түүний мэдлэг, туршлагыг үнэлж баршгүй билээ. Мөн түүнчлэн тус холбоог олон улсын түвшинд гаргах шилжилтийн үйл явцад бидний итгэлийг хүлээсэн, найдвартай дуу хоолой байж чадсан юм. Одоог хүртэл тэрээр бидний дуу хоолойг бусад орнуудад түгээж, зуслангийн талаархи мэдлэгийг дэмжих үйл ажиллагаагаа үргэлжүүлсээр байна.

Кейрол Чили

Кейрол Чили хэдийгээр Дон Чилигээс богино хугацаанд тус холбоонд ажилласан ч гэсэн олон аж лууд ыг хариуцлагатайгаар гүйцэтгэж ирсэн манай шилдэг зохион байгуулагч, идэвхтэй дэмжигч, удирдагч билээ. 2011 онд Кейрол тус холбооны Удирдах Зөвлөлд сонгогдон хамгийн их сорил, шалгуур бүхий портфолиог хариуцан ажилласан юм. Тус холбооны мэдээ, мэдээлэл, сонин хэвлэлийн хуулбарыг дугтуйлж дэлхийн өнцөг булан бүрт байгаа ОУЗХ-ны мянга мянган гишүүдэд шуудангаар хүргэж тэдгээр гишүүдийг нэгэн зэрэг мэдээлэл, харилцаа холбоогоор хангадаг байсныг шинэ үе шатанд шилжүүлэх хариуцлагатай ажилд ихээхэн дэмжлэг үзүүлсэн юм. Өөрөөр хэлбэл сонин хэвлэлийн мэдээлэл, өгүүлэл, нийтлэл, захидал гэх зэрэг мэдээллүүдийг электрон хэлбэрт хөрвүүлж цахим хуудас, олон нийтийн цахим хэвлэл мэдээлэл, цахим сүлжээнд байршуулахад тэрээр ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Түүнчлэн тус холбооны цахим хуудас болон бусад мэдээлэл холбоог төлөвшүүлэх, олны нийтэд хүргэх чухал үүргийг гүйцэтгэсэн. Тус холбооны гишүүдийг мэдээллээр хангах зорилгоор анхны орчуулагчдын багийг үүсгэн санаачилсан юм. Энэ бүх хугацаанд Кейрол нь АНУ-ын зуслангуудад тус холбооны ажлыг сурталчилан таниулж, мэдээ, мэдээллийг түгээх замаар олон улсын зулсангийн талаархи ойлголтыг өгсөн билээ.

Фумио Мороока

1997 онд ОХУ-д “Невский Форум” сэдвээр зохион байгуулагдсан ОУЗХ-ны Их хурлын дараа 2000 онд Япон улсын нийслэл Токио хотод ОУЗХ-ны Их хурлыг зохион байгуулагахад голлох үүрэг гүйцэтгэсэн хүн бол Фумио Мороока билээ. Тэрээр 2000 онд “*Зуслангийн Шинэ Соёл*” нэрийн дор зохион байгуулсан тус их хурлын зохион байгуулах ажлын хэсэгт багтаж тус их хурлын тайланг боловсруулж ОУЗХ-ны Удирдах Зөвлөлд танилцуулж улмаар ОУЗХ-ны Удирдах Зөвлөлд Бүс Нутаг Хариуцсан Төлөөлөгчөөр сонгогдож, 2003 оны “*Дорнын Загалмай Одны дор*” нэрийн дор Австрали улсын Мельбурн хотноо зохион байгуулагдсан ОУЗХ-ны Их хурлын бүс нутгийн зуслангуудын хэлэлцүүлэгт ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм. Тэрээр тус Их хурлын үеэр бүс нутгийнхаа бүх орнуудын төлөөлөгчидтэй уулзаж Азийн Зуслангуудын Холбоо (одоогийн Ази-Номхон Далайн Орнуудын Зуслангуудын Холбоо)-г үүсгэн бий болгох нөхцлийг эхлүүлсэн бөгөөд түүний энэ санаачилгад ОУЗХ болон Ази болон Номхон далайн орнуудын зуслангуудын холбоод үргэлж талархах болно. Япон улсын Үндэсний Зуслангуудын Холбооны идэвхтэн манлайлагч Моро нь тус холбоог Япон улстай нягт харилцаа холбоотой байхад үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан юм.

Түлшиг Түвшин

ОУЗХ-ны Их хуралд шинээр оролцож буй хүмүүст ОУЗХ-ны зуслангуудын талаархи мэдлэг, туршлагыг харилцан солилцох боломжийг олгодог нь тус их хурлын бас нэгэн үр өгөж юм. Үүний нэг жишээ бол 2000 онд Япон улсын Токио хотод зохион байгуулагдсан Их хуралд Монгол улсыг төлөөлж Түлшиг овогтой Түвшин хүрэлцэн ирж бидэнтэй нэгдсэн явдал юм. Англи хэлний бэрхшээлийг эс тооцвол тэрээр өөрийн орны болон бүс нутгийн зуслангуудыг тус холбоотой холбох жимийг бий болгосон бөгөөд ОУЗХ-ны Удирдах Зөвлөлийн бүс нутгийн төлөөлөгчөөр томилогдон ажиллаж байгаад дараа нь Удирдах Зөвлөлийн эрх бүхий Гишүүнээр сонгогдсон. Тэрээр Олон Улсын Хүүхдийн Найрамдал Төв болон бусад зуслангуудын боловсон хүчин, мэргэжилтнүүдийг төлөөлөн ажилласнаар Монголын зуслангуудын талаархи ойлголтыг нээлттэй болгосон юм. Мөн түүний удирдлага дор Монголын Зуслангуудын Холбоо үүсэн байгуулагдаж улмаар Ази Номхон Далайн орнуудын Зуслангуудын Холбооны анхны Их хурлыг Монгол улсад зохион байгуулсан ба олон улсын судалгаа шинжилгээний түншлэл хөтөлбөрийг боловсруулж, зуслангийн залуу удирдагчдад зориулсан “*Маргаашийн Манлайлал*” сэдэвт олон улсын сургалтыг зохион байгуулсан.

Шилдэг удирдагчийг хэмжих нэг шалгуур бол түүний үлдээж буй залгамж халаа юм. Гадаад улсад дипломат албанд томилогдож тус холбоог орхисон ч Монголын Зуслангуудын Холбоо нь түүний залгамж халааг үргэлжлүүлж зуслангийн олон улсын давцанд өөрсдийн хувь нэмрийг оруулсаар байна.

Антон Денисов

Тус холбоо нь ОХУ-ын арвин туршлагатай зуслангуудын үйл ажиллагаатай танилцаж байх явцад Антон Денисов нь тус холбооны Бүс Нутаг хариуцсан төлөөлөгчөөр ажиллаж эхэлсэн билээ. Антон нь Москва, Санкт Петербург хотуудаас гадна бусад хотуудын зуслангуудтай харилцаа холбоотой ажиллаж эхлэснээр бид ОХУ-ын бүс нутгууд дахь зуслангуудын талаар өргөн ойлголттой болсон.Тэрбээр Арманд Болл, Беверли Болл нарын бичсэн Зуслангийн Суурь Менежмент номыг орчуулах ажилд гүн туслалцаа үзүүлсэн бөгөөд ОХУ-д хийсэн олон улсын зуслангийн удирдлагуудын хэд хэдэн удаагийн айлчлалыг зохион байгуулж Олон Улсын Зуслангийн Захиралуудын Сургалтын сургагч багшаар ажилласан юм. Антон нь ОХУ-ын төрийн байгууллагад ажиллахын зэрэгцээ 2017 онд ОУХ-ын Сочи хотод ОУЗХ-ны Их хурлыг зохион байгуулахад томоохон үүрэг гүйцэтгэсэн. ОУЗХ-ны хүчирхэг түншүүдийн нэг бол Оросын Холбооны Улс юм.

Гвин Паул



Гвин Паулыг би 1994 онд зохион байгуулагдсан ОУЗХК-ын "*КУМБАЯА*" Чуулганаас хойш 20 гаруй жилийн хугацаанд мэдэх билээ. Тэр цагаас хойш түүний хувирашгүй дэмжлэг, зүтгэлийг бид олон удаа хүртсэн бөгөөд түүний Их хурал дахь оролцоо, ОУЗХ-ноос зохион байгуулдаг аялал/арга хэмжээнүүд дэх түүний манлайлал, эргэн тойрныхоо хүмүүст зориулж буй түүний нигүүлсэнгүй зүрх сэтгэл, хандлага нь түүнийг ямар их шургуу хөдөлмөрч болохыг гэрчилнэ. Түүний удирдан манлайлах ур чадвараас дурьдвал, тэрээр хэд хэдэн улс орны (ОХУ, Турк, Нигер зэрэг) элчээр ажиллаж олон улсын зуслангийн манлайлагч оюутан залуусыг олон улсын зуслангуудтай холбох үүргийг гүйцэтгэсэн бөгөөд түүний энэхүү уйгагүй хөдөлмөрийн үр шимийг эдгээр залуус ямагт хүртэнэ гэдэгт би итгэл дүүрэн байна. АНУ дахь ОУЗХ-ны элч Дон Чиллигийн үүрэгт ажлыг Гвин хүлээн авч улмаар 2014 онд Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгогдсон юм. Хэдийгээр түүний Удирдах Зөвлөлд ажилласан хугацаа богино боловч түүний оруулсан хувь нэмэр, үзүүлсэн нөлөө асар их юм. Тэд нар бидний хүсэл зорилгыг үргэлжлүүсээр байх болно гэдэгт бид итгэж байна.

2011 онд хийсэн өөрчлөлтүүдийн үндсэн зорилго нь гишүүнчлэлийг өргөжүүлж, зуслангийн үйл ажиллагаанд бусад хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдэж байсан. Тус тайлангийн бас нэгэн зорилго бол 2017 оны Их хурал, тус холбооны элч, гишүүн, удирдах албан тушаалтнууд та бүхний ололт амжилтыг батлан харуулахад чиглэгдэж байгаа билээ...

Удирдах Зөвлөл нь эдгээр ололт амжилтын цаашдын хэмжүүр болно. ОУЗХ-ны Удирдах Зөвлөлийг эдгээр 7 гишүүд орхиж, халаагаа өгснөөр бидний бүтээмж, манлайлалд сөрөг нөлөөлөл гарч болзошгүй гэдгийг төсөөлөхөд хялбар байж болох юм. Гэхдээ Монгол улс болон Түвшингийн тухайд тэд цаашид тус холбоонд ажиллах чадварлаг шинэ боловсон хүчин, манлайлагчдыг бэлтгэн үлдээсэн юм.

Энэ удаагийн сонгуульд ОУЗХ-ны түүхэнд байгаагүй олон тооны нэр дэвшигчид ОУЗХ-ны Удирдах Зөвлөлд нэр дэвшсэн бөгөөд бид элч нарын бүлгүүд дунд явуулсан энэхүү сонгуулийг үнэнч шударга, ил тод зохион байгуулж чадсан. Удирдах Зөвлөлд шинээр сонгогдсон гишүүд маань тус тусын ажлыг хүлээн авч өөрсдийн чиглэл, салбартаа өөрчлөлт, шинэчлэлт хийхээр шамдан ороод байна.

Ирэх жил бидний хийж бүтээсэн олон ажил, зорилтуудыг дараагийн Тайланд тусгасан байна гэдэгт би итгэлтэй байна. Ингээд миний бие өөрийн дуртай шүлгийг та бүхэндээ өргөн барьж байна. Энэ шүлгэнд дурьдагдах “хөгшин буурал толгой” гэдэг үгийн талаар ямар нэг тайлбар хэлэхийг хүсэхгүй байна. Гэвч тэд бол жинхэнэ гүүр бүтээгчид билээ...

An old man, going a lone highway,
Came at the evening, cold and gray,
To a chasm vast and deep and wide,
Through which was flowing a sullen tide.
The old man crossed in the twilight dim,
The sullen stream had no fears for him.
But be turned when safe on the other side
And built a bridge to span the tide.
"Old man", said a fellow pilgrim near,
"You are wasting strength with building here;
Your Journey will end with the ending day,
And you never again will pass this way.
You have crossed this chasm deep and wide,
Why build the bridge at the eventide?"
The builder lifted his old gray head - -
"Good friend, in the path I have come," he said,
"There follows after me today
Some youth whose feet must pass this way
This chasm that has been nothing to me,
To a youth may a pitfall be
He, too, must cross in the twilight dim.
Good friend, I am building that bridge for him.”

John Jorgenson

Гишүүнчлэл

ОУЗХ-ны гишүүнчлэл)бүрэн эрхт гишүүн болон түнш(нь 2016-2017 онд 1%-иар 2015-2017 онд 4%-иар өссөн үзүүлэлттэй байна. 2016 оны үзүүлэлттэй харьцуулж үзэхэд Зуслангийн Холбооны гишүүнчлэл 70% -иар, Зуслангийн гишүүнчлэл 12%-иар, Байгууллагын гишүүнчлэл 31%-иар өссөн байна. Гишүүд болон Түншүүд ОУЗХ-ны цахим хуудасны онлайн форум болон тухайн жилийн туршид зохион байгуулагдсан зуслантай холбоотой төрөл бүрийн арга хэмжээнд оролцохоор бүртгүүлжээ (Олон Улсын Зуслангийн Холбооны Их хурал, Олон улсын Зуслангийн Захирлуудын сургалт, Зуслангуудын хурал, семинар):

Түншүүд (төлбөргүй):	3911
Зуслангийн Холбоод:	17
Зуслангууд:	337
Хувь хүмүүс:	85
Байгууллагууд:	67
2017 оны нийт Гишүүнчлэл, Түншлэл	4417

Онлайн бүртгэл: ОУЗХ-ны шинэ цахим хуудсанд шинээр нэгдэх, гишүүнчлэлээ шинэчлэх, түншлэлийн статусын хүсэлт гаргахад чиглэсэн хэрэглэгчдэд хялбар онлайн процессийг бий болгоод байна. Бидний ирээдүйн гишүүд хандив товчлуурыг сонгосноор Билл Боукер Тэтгэлэгийн Сан болон ОУЗХ-ны Баттерфлай Санд хандив өргөх боломжтой.

Зуслангуудын Холбоотой Харилцаа холбоо тогтоох тухай: дэлхийн зуслангуудын холбооны зуслан болон өсвөр залуучуудын хөгжилд чиглэсэн лидерүүдтэй холбогдох сүлжээг бий болгохоор ОУЗХ-ны Удирдах Зөвлөл нь үндэсний болон бүс нутгийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Америкийн Зуслангуудын Холбоотой байгуулсан хамран ажиллах гэрээг 2013 оны 2 дугаар сард сунгаж АЗХ-ны Боловсролын Холбоо хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн. Үүний үр дүнд өдгөө ОУЗХ нь АЗХ-ны Бизнес Түнш болсон бөгөөд Олон Улсын Зуслангуудын Холбооны Их хурал нь Тасралтгүй Боловсролын Кредитийг олгох батламжийг гардан авсан.

Австралийн Зуслангуудын Холбоотой байгуулсан Түншлэл нь зургаа дахь жилдээ үргэлжилж байгаа бөгөөд тус холбооны бүх гишүүд нь ОУЗХ-ны бүрэн эрхтэй гишүүнчлэлтэй юм.

Харилцан ашигтай хамтын ажиллагааны загвар боловсруулахад бусад холбоодод туслах хэлэлцүүлэгийг 2018 онд мөн үргэлжлүүлэн зохион байгуулна.

Холбооны Цахим Сүлжээ: ОУЗХ нь дэлхийн өнцөг булан бүр дэх зуслангийн холбоодын ерөнхийлөгчид болон гүйцэтгэх ажилтнуудын хооронд одоо байгаа харилцаа холбоо болон нөөцийг хуваалцах үйл ажиллагааг зохицуулах болно. Холбооны Сүлжээ нь ОУЗХ-ны ерөнхийлөгч Жон Йоргенсоны Зөвлөх Зөвлөлийн гишүүн юм. ОУЗХ нь зуслангуудын группуудын динамик бүлгүүдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэхэд шаардагдах холбоо барих мэдээллийг цуглуулдаг.

Холбооны Сүлжээ нь Олон Улсын Зуслангуудын Холбооны Их хурлаар албан ёсоор биечлэн ирж өрнүүлдэг хэлэлцүүлэг юм (дараагийнх 2020 онд болно).

Гишүүнчлэлийн ангилал ба давуу талууд

Түншлэл	Төлбөргүй (гурван жил тутамд сэргээгдэнэ) ОУЗХ-ноос Тогтвортой Харилцаа Холбоотой байх ОУЗХ-ны цахим сүлжээнд нэвтрэх
Зуслангийн Гишүүнчлэл / Зуслангийн Байгууллагын Гишүүнчлэл	180 доллар (Америк эсвэл Канад) (3 жил хүчинтэй) Гишүүнчлэлтэй зуслан, байгууллагуудад зориулсан вэб линк болон жагсаалт ОУЗХ-ны Их хуралд зориулсан хөнгөлөлт (Олон улсын болон бүс нутгийн): Гишүүнчлэлтэй Зулсангийн Байгууллага- Гишүүнчлэлтэй Зуслангийн Байгууллагын 5 хүртэл оролцогчдод хөнгөлөлт үзүүлдэг Гишүүнчлэлтэй Зуслан-Гишүүнчлэлтэй Зуслангийн бүх оролцогчдод хөнгөлөлт үзүүлдэг Гишүүнчлэлийн үнэмлэх ОУЗХ-ны үйл ажиллагаанд санал оруулах ОУЗХ-ны Удирдах зөвлөлд ажиллах Маркетингийн материалд ОУЗХ-ны логог ашиглах ОУЗХ-ноос байнгын харилцаа холбоотой байх ОУЗХ-ны Цахим сүлжээнд нэвтрэх АНУ-ын АЗХ-ны үнэ төлбөргүй нэг жилийн хугацаатай гишүүнчлэл ОУЗХ-ны Цахим сүлжээнд нэвтрэх бүрэн эрх
Зуслангийн Холбооны Гишүүнчлэл	180 доллар (Америк эсвэл Канад) (3 жил хүчинтэй) Гишүүнчлэлтэй зуслан, байгууллагуудад зориулсан вэб линк болон жагсаалт ОУЗХ-ны Их хуралд зориулсан хөнгөлөлт (Олон улсын болон бүс нутгийн): Зуслангийн Холбооны Ажилтан/Удирдах зөвлөлийн гишүүд Гишүүнчлэлийн үнэмлэх ОУЗХ-ны үйл ажиллагаанд санал оруулах ОУЗХ-ны Удирдах зөвлөлд ажиллах Маркетингийн материалд ОУЗХ-ны логог ашиглах ОУЗХ-ноос байнгын харилцаа холбоотой байх ОУЗХ-ны Цахим сүлжээнд нэвтрэх ОУЗХ-ны Цахим сүлжээнд нэвтрэх бүрэн эрх ОУЗХ-ны Холбоодын Сүлжээний гишүүнчлэл
Хувь хүнд олгох гишүүнчлэл (Бүрэн эрхтэй)	ОУЗХ-ны Их хуралд оролцох хөнгөлөлт (Олон улсын болон бүс нутгийн): Гишүүнчлэлийн үнэмлэх ОУЗХ-ны үйл ажиллагаанд санал оруулах ОУЗХ-ны Удирдах зөвлөлд ажиллах ОУЗХ-ноос байнгын харилцаа холбоотой байх ОУЗХ-ны Цахим сүлжээнд нэвтрэх АНУ-ын АЗХ-ны үнэ төлбөргүй нэг жилийн хугацаатай гишүүнчлэл

2017 оны эцсийн байдлаар тус Холбоонд **95 орны 4417 гишүүд, түнш** байна.

Афганистан	Алжир	Аргентин	Австрали	Австри
Азербайжан	Бангладеш	Беларусь	Бермуда	Болив
Бразил	Британийн Виржин Арлууд		Болгар	Камбож
Камерун	Канад	Кайманы арлууд	Хятад	Колумби
Коста Рика	Хорват	Кипр	Чех	Дани
Конгын БНУлс	Доминикан	Эквадор	Египет	Сингапур
Франц	Гүрж	Герман	Гана	Грек
Хонг Конг	Унгар	Исланд	Энэтхэг	Индонез
Ирланд	Израиль	Итали	Ямайка	Япон
Жордан	Казахстан	Кени	Латви	Либери
Малайз	Мавритани	Мексик	Молдова	Монгол
Монтенегро	Мянмар	Балба	Нидерланд	Нигери
Пакистан	Палестин	Панам	Папуа Шинэ Гвиней	Перу
Филиппин	Польш	Португали	Бенинийн БНУлс	Румын
ОХУ	Руанда	Саудын Араб	Серби	Сьерра-Леон
Словак	Өмнөд Африк	БНСУ	Испани	Шри Ланк
Швейцарь	Тайвань	Тайланд	Того	Тунис
Турк	Уганда	Их Британи	Украин	Уругвай
Арабын нэгдсэн Эмират	АНУ	Узбекистан	Венесуэл	Вьетнам
Зимбабе				

Шилдэг Түнш 15 улс

2017.12.31-ны байдал		**орнууд**
1	Венесуэл	1233
2	Австрали	586
3	АНУ	364
4	Канад	297
5	Турк	241
6	Мексик	174
7	Орос	156
8	Хятад	130
9	Грек	112
10	Малайз	69
11	Уругвай	48
12	Хонг Конг	46
13	Сингапур	40
14	Япон	38
15	Колумби	37

Бүрэн эрхт Гишүүнчлэлтэй шилдэг 15 улс

2017.12.31-ны байдал		**Гишүүн улс**
1	Австрали	239
2	Хятад	59
3	АНУ	30
4	Орос	27
5	Канад	24
6	Мексик	16
7	Япон	8
8	Венесуэл	7
9	Турк	7
10	Испани	7
11	Монгол	5
12	Грек	4
13	Малайз	4
14	Колумби	4
15	Пакистан	4

ОУЗХ-ны Хөгжилийн асуудал хариуцсан дарга **Гонзало Велоз** (Gonzalo Veloz) нь ОУЗХ-ны бүх гишүүдийн хувийн мэдээллийг хадгалах, түүнчлэн эдгээр гишүүд мэдлэг, мэдээллээ бусадтайгаа хуваалцах, солилцох, сонирхож буй асуудлаа хэлэлцүүлэх, ОУЗХ-ноос зохион байгуулж буй үйл ажиллагаанд нэгдэх, бүртгүүлэхэд зориулсан тус холбооны цахим сүлжээг хариуцан ажилладаг. ОУЗХ-ны цахим сүлжээ нь ОУЗХ-нд нэгдсэн Холбоодод үзүүлдэг дэмжлэгийг нэмэгдүүлж, дэлхий дахины мэдээ, мэдээллийг солилцож, жишиг тогтоох судалгаа (бенчмарк) хийх замаар тус холбооны Гишүүд, Түншийн тоог өсгөх хөшүүрэг болох юм. ОУЗХ-ны цахим сүлжээг бүрдүүлэгч янз бүрийн модулиуд нь олон төрлийн хэрэглээний боломжийг олгодог. Эдгээр модулиуд болон боломжуудыг доор нарийвчлан тайлбарласан.

ОУЗХ-ТОЙ (ICF CONNECT) ХОЛБОГДСОН ЭНГИЙН ХЭРЭГЛЭГЧДЭД ОЛГОДОГ БОЛОМЖУУД

 Гишүүний Мэдээллийн Сан: Тус мэдээллийн сангаар дамжуулан ОУЗХ-ны бүх түнш, хувь хүн, зуслан, холбооны гишүүд өөрсдийн хувийн болон холбоо барих мэдээлэл, сургалт хөгжлийн хөтөлбөрийн сонголтуудыг шинэчилж бусад гишүүдийн үйл ажиллагааг дэмжиж нэгдэх боломжтой.

 Архив: ОУЗХН-ны гишүүд нь зуслангийн үйл ажиллагаатай холбоотой файл, зураг, холбоосууд зэрэг бичиг баримтыг онлайн хэлбэрээр хадгалснаар ОУЗХ-ны бусад гишүүд сонирхсон чиглэлийн дагуу тэдгээр мэдээлэлтэй танилцах боломжтой.

 Гишүүдийн Форум: Цахим форум нь урьдчилан тодорхойлсон сэдэв, ангиллын хүрээнд хэлэлцүүлэгт нэгдэх, харилцан ярилцах, ОУЗХ-ны бусад гишүүдтэй санал бодлоо хуваалцах боломжийг олгодог.

 Тэмдэглэлт Үйл Явдлын Хуанли: ОУЗХ-ны гишүүдэд зориулсан интерактив календар нь ОУЗХ-ны бүх тэмдэглэлт үйл ажиллагаа болон тэдгээрийн зохион байгуулагдах газрын хаяг байршил, огноо, бүртгэлийн хураамж, бусад оролцогчдын талаархи үндсэн гол мэдээллийг авах эсвэл бүртгүүлэх боломжийг олгодог.

УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНУУДАД ОЛГОДОГ БУСАД БОЛОМЖУУД

Гишүүнчлэлийн Удирдлага

Дүн шинжилгээ хийх хяналтын самбар: Хувийн мэдээлэл, Уулзалт хэлэлцээр

2017 ОНД БОЛСОН ҮЙЛ ЯВДАЛ, АРГА ХЭМЖЭЭ

 2017 оны 3 дугаар сард бүх гишүүдэд зориулсан Албан ёсны нээлт

 Элч төлөөлөгч нарын хандалтын хэсгийг бий болгож шинэ Элч нарт нэвтрэх эрхийг гардуулсан бөгөөд ялангуяа шинэ элч нарт зориулсан форумын хэсгийг бий болгов.

 Элч нарын харилцаа холбоог хариуцсан Пабло Касас (Pablo Casas) нь шинэ Элч нартай холбогдох харилцаа холбоог санаачилсан бөгөөд шинэ элч нарыг флатформд оролцоход нь түлхэц үзүүлсэн.

 Бусад нэвтрэх/хандалтын түвшинг 4G-тэй хамт хянаж байгаа бөгөөд 2018 оны 2 дугаар сар гэхэд бэлэн болгохоор ажиллаж байна.

 Бага хэмжээтэй флатформ дахь 4G-тэй харилцах үйл ажиллагааг сайжруулах

 Идэвхжүүлэх видео бичлэгийг 2018 оны 1 дүгээр сарын эцэс гэхэд Фейсбүүк хуудас болон группэд байршуулах

 ОУЗХ-ны Цахим Сүлжээний Ажлын Хэсэг долоо хоног тутмын сэдвүүдийг үүсгэх админы профайлыг удирдан ажиллаж байна.

 12 дугаар сарын дунд үе гэхэд өнгөрсөн жилийн мөн үеийнхтэй харьцуулахад Форумын оролцоо 50%-иар өссөн байна.

ДАРААГИЙН АЛХАМ

Бид интернет ашиглан дэлхийн хамтын нийгэмлэгийг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг харж байна. Үүний тулд бид дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхээр болоод байна. Үүнд:

- ОУЗХ-ны Удирдах Зөвлөлийн гишүүдийг форум болон нөөцийн номын сангаар дамжуулан мэдлэг туршлагаа хуваалцахаар урих.
- ОУЗХ-ны Удирдах Зөвлөлийн гишүүдийг хамруулсан Фейсбүүк видео бичлэгийг хэрэглэгчдэд хүргэх ажлыг дэмжиж ажиллах.
- Форумын агуулгыг баяжуулах зорилгоор долоо хоног тутам шинэ сэдэв өрнүүлэх.
- Үйл ажиллагааг өргөжүүлэн тэлэх зорилгоор өөрсдийн түнш, гишүүдэд фрофайл үүсгэх урианлга гаргах хүсэлтийг Элч нарт хүргүүлэх.
- ОУЗХ-ны Цахим Форумаар дамжуулан АЗХ-ны 2018 онд зохион байгуулагдах хуралд өөрсдийн мэдлэг, туршлагыг хуваалцахыг бүх гишүүдэд урианлах.
- Америкийн Зуслангуудын Холбооны Жил бүрийн Чуулганы үеэр ОУЗХ-ны Олон улсын Цугларалт гэх зэрэг үнэ төлбөргүй арга хэмжээг зохион байгуулах замаар Тэмдэглэлт үйл ажиллагааны бүртгэлийн хэсгийн ашиглалтыг идэвхжүүлэх.
- Төлбөртэй үйл ажиллагаанд бүртгүүлэхэд шаардагдах ОУЗХ-ны PayPal дансны холбоосыг ОУЗХ-ны Цахим сүлжээнд байршуулах
- ОУЗХ-ны Цахим сүлжээнд гадны тэмдэглэл үйл ажиллагааг (ОУЗХ-ны үйл ажиллагаанаас бусад) оруулах тохиолдолд тухайн үйл ажиллагаанд оролцох төлбөр, хураамж, төлбөр хийх аргачлалын талаар ОУЗХ-ны Удирдах Зөвлөлтэй тохиролцох ёстой.

ОХУ-НЫ СОЧИ ХОТНОО ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ОЛОН УЛСЫН ЗУСЛАНГУУДЫН ХОЛБООНЫ ИХ ХУРАЛТАЙ ХОЛБООТОЙ ОНЦЛОХ МЭДЭЭЛЛҮҮД

Олон Улсын Зуслангуудын Холбооны Их хурлыг хэд хэдэн үндэслэлээр онцгой тэмдэглэлт үйл явдал гэж үздэг юм. 2017 онд ОХУ-ын Сочи хотноо зохион байгуулагдсан Олон Улсын Зуслангуудын Их хурлын талаар ямар нэгэн тайлбар хэлэх нь илүүц бизээ.

Олон улсын зуслангийн 35 жилийн түүхэнд Их хурлыг 11 удаа зохион байгуулжээ. Хуралд оролцогчид нь зохион байгуулагч орны зуслангийн соёлтой танилцаж зуслангийн талаар дэлхий нийтийн мэдлэгийг олж авдаг нь тус их хуралд оролцох үндсэн нэг шалтгаан юм.

Өмнө нь зохион байгуулагдсан хурлуудтай харьцуулан үзэхэд энэ удаагийн Их хуралд ОХУ хамгийн том баг бүрдүүлэн оролцсон юм. Зохион байгуулагч орны оролцогчдын тоо болон гаргаж буй идэвхи зүтгэлийн хувьд давамгай байх нь зүйн хэрэг юм. Тус Их хуралд 1000 гаруй төлөөлөгчид хүрэлцэн ирсэн нь сүүлийн 10 жилд зохион байгуулагдсан хурлууд дотроос хамгийн их хүрээг хамарсан Их хурал болж чадсан юм.

Тус хурлын бас нэгэн онцлог зүйл бол ОХУ-ын Засгийн газар тус арга хэмжээнд ихээхэн анхаарал хандуулж гол үүргийг гүйцэтгэсэн явдал байсан юм. ОХУ-ын Боловсрол, Шинжлэх Ухааны Яам болон саяхан үүд хаалгаа нээсэн Оросын Зуслангуудын Холбоо нар хамтарч 2017 оны ОУЗХ-ны Их хурлыг зохион байгуулсан бөгөөд эдгээр байгууллагууд Их хурал зохион байгуулахад тулгарч болзошгүй бэрхшээлийг арилгах флатформоор хангаж чадна юм.

Аливаа зуслангийн байгууллага нь өөрсдийн зохион байгуулж буй үйл ажиллагааг хариуцдаг ч гэсэн тэдгээрийг хариуцан ажилладаг хүмүүсээс бүрдэж байдаг. Тэгвэл ямарваа нэгэн зүйлийг тусгайлан хүлээн зөвшөөрүүлэхэд эрсдэл үргэлж дагаж байдаг бөгөөд энд нэр дурдагсан хүмүүсийг 2017 оны ОУЗХ-ын Их хурлын түүхэнд тэмдэглэх үлдээх ёстой. Бид ОУХ-ын сайд Вениамин Кагановтой Москва хот дахь түүний албан өрөөнд анх уулзсан цагаас эхлэн тэрбээр 2017 оны ОУЗХ-ны Их хурлыг зохион байгуулах бидний зүтгэлийг туушгайгаар дэмжсэн билээ. Хэдийгээр зарим нэг бэрхшээл тулгарч байсан ч гэлээ ноён Каганов Сочи дахь хурлыг амжилттай болгох гэсэн бидний хүсэл сонирхолыг хүндэтгэж өөдрөгөөр хүлээн авсан юм. Орлёнок зуслангийн захирал, ОХУ-ын Зуслангуудын Холбооны Ерөнхийлөгч бөгөөд ОУЗХ-ны Их хурлыг Зохион Байгуулах Хорооны дарга Александр Джеус Орлёнок зуслан болон бусад харьяалагдах газруудаас Их хурал зохион байгуулахад шаардлагатай ажлуудыг гүйцэтгэх хүмүүсийг дайлчилсан бөгөөд Олег Кудряцев (Мосгортур) мөн Ксениа Фаресова нар тус төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүмүүсийг нэгтгэж чадсан гайхалтай ур чадвартай хүмүүс билээ. Тэд найман сарын хугацаанд Чуулганы төсөв, төлөвлөгөөний ноорог, загварыг боловсруулж Сочи хотноо болсон Их хурлыг гайхалтай зохион байгуулж чадсан гэдийг энд дурьдах нь зүйн хэрэг биз ээ.

Их хурлыг зохион байгуулах газар, тээвэр, орон байр, ложистик, технологийн асуудлуудыг богино хугацаанд шийдвэрлэхийн тулд өөрсдийн өдөр тутмын ажил албаа тэр ч байтугай хувийн амьдралыг хойш тавьж тус хурлыг маш амжилттай зохион байгуулсан Их хурлын баг хамт олонд гүн туслалцаа үзүүлсэн билээ.

ОУЗХ-ны зүгээс тус холбооны Хөтөлбөр зохион байгуулах Хороонд ажилласан Жилл Дандас (Jill Dundas) –ыг нэрлэх нь зүйтэй. Тэрээр олон улсын илтгэгч нарыг хуран цуглуулж чадсан төдийгүй тус хөтөлбөрийг даацтай болгох нөхцлийг үүгээр бүрдүүлж чадсан юм.

Бидний зайлшгүй дурдах ёстой сүүлийн хүн бол Сочи хотод тус чуулганыг амжилттай зохион байгуулах хүртэл 3 жилийн туршид ОУЗХ-ын дуу хоолой болж чадсан Валерий Костин юм. Тэрээр тус хурлын үеэр орчуулга хийх, зочид хүлээн авах, гэрээ хэлцэл байгуулах, тулгарсан асуудлыг шийдвэрлэх зэрэг олон асуудлыг хариуцан ажилласан бидний түнш, төлөөлөгч, элч, тулах нөхөр, анд найзын үүргийг гүйцэтгэсэн.

Бидний ажилд гүн туслалцаа, дэмжлэг үзүүлсэн эдгээр зургаан нэр бүхий хүмүүсийн ард олон зуун сайн дурын ажилтан, албан хаагчид “Дэлхийн хүүхдүүдэд аз жаргал, баяр хөөр бэлгэлэх”-ээр нэг баг хамт олон болж ажилласан гэдгийг дурдахад бидэнд таатай байна. Энэ бүх үйл явдлыг эргэн харахад эдгээр хүмүүс, хамт олон Их хурлын бүх төлөөлөгчдөд ч бас баяр хөөр авчирсан юм.

“Сочид уулзацгаая” гэсэн уриа түүх болон үлдэж “2020 онд Шенженд уулзацгаая” гэдэг одооноос эхлэн бидний зорилт болж байна!

Танилцах Үдэшлэг

Их хурлын нээлтийн ажиллагаа

Нигер улсын танилцуулга

Пакистан улсын танилцуулга

Женни Боукерт “Дружба 2016” шагнал гардуулах ёслол

Галина Суковейкод “Дружба 2017” шагнал гардуулах ёслол

ОУЗХ-ны Их хурлыг Зохион байгуулах Хорооны дарга Александр Джеуст баяр хүргэх ёслолын ажиллагаа

2020 онд ОУЗХ-ны Их хурлыг БНХАУ-ын Шенжен хотод зохион байгуулах эрхийг БНХАУ-ын төлөөлөгчдөд гардуулах ёслолын ажиллагаа

Элч

ОУЗХ-ны гишүүнчлэлтэй улс орон бүр дэх ОУЗХ-ны сайн дурын гишүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн ОУЗХ-ны удирдлагын стратегийн салшгүй нэг хэсэг бол тус холбооны Элч нар билээ. Улс орон бүр элч нараа сонгон шалгаруулахдаа нэр дэвшүүлэх, томилох, сонгох зэрэг янз бүрийн арга механизмыг ашигладаг.

ОУЗХ-ны Элчийн бүрэн эрх нь дараагийн Олон Улсын Зуслангуудын Холбооны Их хурал хүртэл (гурван жил тутам) хүртэл үргэлжилдэг.

Элч нь дараагийн Их хурал зохион байгуулах хүртэл дараахи үүрэг, хариуцлагыг хүлээдэг. Үүнд:

- ОУЗХ-ны Удирдах зөвлөлийг төлөөлөн өөрийн улс оронд ОУЗХ-ны хөдөлгөөнийг өрнүүлэх,
- Өөрийн улс оронд ОУЗХ-ны гишүүдийн нэгдэлийг бий болгож хуран чуулах арга хэмжээг хөхүүлэн дэмжих,
- Өөрийн улс орны хэмжээнд ОУЗХ-нд шинэ гишүүдийг (бүрэн эрхт болон хараат бус) нэмж элсүүлэх ажлыг зохион байгуулах,
- Үндэсний болон олон улсын хэмжээнд зусланд амрагч хүүхдүүд, багш нарын солилцооны хөтөлбөрийг зохион байгуулж гишүүдийн холбоо харилцааг хөгжүүлэх,
- Өөрийн улс орны нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг зуслангуудын талаархи мэдээ, мэдээллийг ОУЗХ-нд тогтмол ирүүлэх,
- Олон улсын зуслангууд, ОУЗХ-ны хөтөлбөр, үйлчилгээний талаархи мэдээллийг улс орныхоо ОУЗХ-ны гишүүдэд түгээх,
- ОУЗХ-ны Ерөнхий Ассемблейн гишүүн болохын хувьд ээлжит Олон Улсын Зуслангуудын Холбооны Их Хуралд ОУЗХ-ны Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, мэдээ, мэдээлэл түгээх зэрэг ажлуудыг гүйцэтгэх,
- Шаардлагатай тохиолдолд бүс нутгийн зохицуулагч нарт дэмжлэг үзүүлэх, мөн
- ОУЗХ-ны ажилд шаардлагатай, тохиромжтой гэж үзсэн арга хэлбэрээр тусламж үзүүлнэ.

Одоо сонгогдсон элч нар: Тус холбоонд 59 элч нараас бүрдсэн цөм групп байдаг бөгөөд нэгээс олон Элч нар шаарддаг ОУЗХ-ны гишүүнчлэл бүхий 90 гаруй улс тус холбоонд нэгдээд байна.

АВСТРАЛИ	Maree Feutrill
АРГЕНТИН	Alejandro Luque Gaston
АВСТРИ	Bernd Seidl
АЗЕРБАЙЖАН	Ali Badalov
БАНГГЛАДЕШ	Rezaul Amin
БЕЛАРУС	Vladimir Rudoy
БРАЗИЛ	Sandra Urioste
БОЛГАРЬ	Stanka Shopova
КАМБОДЖИ	Sem Sereysousdey Vannak Nai
КАНАД	Gabrielle Raill
ХЯТАД	Josh Lee
КОЛУМБ	Angela Gómez Montoya
КОНГО	Toussaint Balumuene
ХОРВАТ	Anita Torbarina
КИПР	Mevlit Orhun Champouridis Takis
ЧЕХ	Kamil Cakin
ФРАНЦ	Kuznetsov Sergey
ГҮРЖ	Goguadze Gocha
ГЕРМАН	Jan Vieth
ГРЕК	Kirki Athanasiadou
ХОН КОНГ	Yiu Yik Ming, Edmond
ИСЛАНД	Anna Margrét Tómasdóttir
ИНДОНЕЗ	Putu Shanti
ИРЛАНД	Stott Caroline Muldon Sinead
ИЗРАЙЛ	Lichtenberg Shiry Meiron
ИТАЛ	Francesco Castiglione
ЯПОН	Shin Takahashi
ЙОРДАН	Maen Odeh
СОЛОНГОС	Hyunhee Park
ЛАТВИ	Svetlana Šibko-Šipkovska
МАЛАЙЗ	Aing Granda
МЕКСИК	Oscar Bücheler de Pavia
МОНГОЛ	Chultem Byambasuren
НИГЕР	Father Mark Obayi
ПАКИСТАН	Muhammad Ali Rizvi
ПАНАМ	Anamari Eskildsen
ПАПУА ГВИНЕЙ	James Robert
ПЕРУ	Denisse Calderon Lopez Larry Monzon
ФИЛЛИПИН	Krzysztof Alchimowicz
ПОЛЬШ	Ana Manițiu Ozmen
РУМИН	Valery Dolgikh
ОРОС	Ruberwa Jean de Dieu
РАВАНДА	Mike Lim
СИНГАПУР	Malefane Kabelo Lilienthal Philip
ӨМНӨД АФРИК	Carolina Fleix
ИСПАНИ	Rikley Joe
ШВЕЙЦАРЬ	Stuart Alexander
ТАЙВАН	Pakawat Peter Smith
ТАЙЛАНД	Zanklassou Kokou Isidore
ТОГО	Oumaima Hamdi
ТУНИС	Rifat Can Barutcugil
ТУРК	Alex Mushabe
УГАНДА	Clive Clifford
АНГЛИ	Rodion Zhyzneyvskyy Olga Tsiupryk
УКРАЙН	Steve Baskin
АНУ	Luis Francisco Rivero
ВЕНЕСУЭЛ	Dao Hien Thu
ВЬЕТНАМ	

Олон Улсын Зуслангийн Захирлуудын Сургалт / ОУЗЗС/

ОУЗХ-ны Удирдах зөвлөлийн гишүүн **Андрю МакГукиан** (Andrew McCuckian), ОУЗЗС-ын зохицуулагч **Конние Кютеллиер** (Connie Coutellier) нар ирүүлсэн тайландаа олон улсын хэмжээнд ойролцоогоор 710 гаруй төгсөгч ОУЗЗС-нд хамрагдсан байна гэжээ. 2017 оны байдлаар дараах сургалтуудыг явуулжээ. Үүнд:

Улс	Огноо	Сургалтанд хамрагдагсдын тоо
БНХАУ	2017 оны 3-р сар	32
Австрали	2017 оны 9-р сар	20
Канад	2017 оны 10-р сар	26
ОХУ	2017 оны 10-р сар	13, нэмэгдэж 7 “Сургагч багш”
Сингапур	2017 оны 12-р сар	

2018 оны урьдчилсан төлөвлөгөөнд Колумб, Австрали, БНХАУ-д зохион байгуулагдах ОУЗЗСургалтууд багтсан. Тус сургалтыг явуулдаг 24 Удирдагч багш нар байдаг.

Олон Улсын Зуслангуудын Холбооны Их хурал болон Ази-Номхон далайн орнуудын Зулангуудын Холбооны Их хурлын зохион байгуулагч нартай хамтарч сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг зохион байгуулахаар дараахи ОУЗЗСургалтын Зохицуулагчдыг томилоод байна. Үүнд:

Конние Кютеллиер (АНУ)
Теннант Киу (Сингапур)
Эндрю МакГукиан (Австрали)
Пол Колагиури (Австрали)
Жуан Марио Гутиеррез (Колумб)

Одоо ажиллаж байгаа Удирдагч багш нар:

Теннант Киу (Сингапур)
Тони Тан (Сингапур)
Мохамид Ануар (Сингапур)
Брендан Смит (Австрали)
Пол Колагиури (Австрали)
Жуан Марио Гутиеррез (Колумб)
Толгахан Сонмез (Турк)
Назли Озкелик (Турк)
Майк Лим (Сингапур)
Жереми Танг (Сингапур)
Нанк Кай Яп (Малайз)
Марее Фиутрилл (Австрали)
Бек Фокс (Австрали)
Женнифер Дандас (Канад)
Рифат Кан Баруткугил (Турк)
Шима Али (Сингапур)
Гари Лим (Сингапур)
Эндрю МакГукиан (Австрали)
Мэтт Бөүкер (Австрали)
Саймон Самбрано (Венесуэл)
Донна Вилконсон (Канад)
Утку Топраксевен (Турк)

Matt Bowker (Australia

Судалгаа шинжилгээ

ОУЗХ-ны Их хурлын үеэр тусгай судалгаа шинжилгээний форум зохион байгуулагдаагүй боловч судалгаа шинжилгээний аажлуудыг хэлэлцүүлсэн хэд хэдэн зөвлөгөөнүүд болсон талаар Судалгааны ажил удирдагч Доктор Дэб Биалески, Доктор Стефен Файн нар ирүүлсэн тайландаа дурьдсан байна. Үүнд:

- АНУ-ын САТСН хөтөлбөрийн зохицуулагч Кати Чичестерийн *"Хичээлээс гадуурхи болон Зуны сургалтын хөтөлбөрт Эрүүл хүнс, Идэвхтэй хөдөлгөөнийг сурталчлан таниулах нь"* сэдэвт хүүхдийн эрүүл мэнд, зөв зан төлөвт нөлөөлж, жингийн илүүдлийг багасгах үйл ажиллагаа явуулах мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх болон менежментийн ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн судалгаанд суурилсан САТСН хөтөлбөр
- Бант Иззет Байсал Их Сургуулийн доктор Муберра Селебигийн "*Турк улс дахь Зуслангуудын байршлийн зургийг салбар тус бүрээр гаргах нь"* сэдэвт Турк улс дахь зуслангуудын байршлийн нарийвчилсан зургийг гаргах зорилгоор салбар зуслангуудын байршилд дүн шинжилгээ хийсэн судалгааны ажил
- Япон улсын Нагасаки Олон Улсын Их Сургуулийн Доктор Кениа Кумагайн "*Коллежийн оюутнууд 5 өдрийн Цасны Спорт Зусланд хамрагдах үед болон хамрагдсаны дараа тэдний сэтгэл зүйд гарсан Өөрчлөлтүүд*" сэдэвт судалгааны ажил
- АЗХ-ны Судалгаа шинжилгээ хариуцсан захирал Доктор Лаури Брауны Америкийн Зуслангуудын Холбооны Судалгаа шинжилгээ 360 –ын тойм. 2017 оны Хавар эхлүүлсэн АЗХ-ны 5 жилийн Нөлөөллийн Судалгаа нь өсвөр залуу үеийг мэргэжлээ сонгох, амьдралын гараагаа эхлүүлэхэд зуслан хэрхэн, яаж нөлөөлдөг болохыг илрүүлэхэд чиглэсэн байна.

2020 онд БНХАУ-д болох ОУЗХ-ны Их хурлын үеэр зохион байгуулагдах эрдэм шинжилгээний форумыг өмнөх форумын загвараар зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Судалгаа шинжилгээний Удирдагч нар тус чуулганы зохион байгуулагч нартай хамтран ажиллаж байна.

АНУ-ын Зуслангуудын Холбоо болон Канадын Зуслангуудын Холбооны Удирдах зөвлөлүүд АЗХ-ны Нөлөөллийн Судалгаа (Судалгаа шинжилгээ 360) –нд оролцохоор тохиролцоонд хүрэв. 2018 оны хавар гэхэд холбогдох мэдээллүүдийг Канадын зуслангуудаас цуглуулж авсан байна. Гадна орчны судалгааны Рутледж Олон Улсын Гарын авлага (2016)-д багтсан *Зулсангийн талаар мэдлэг, туршлага: Гадна орчноор дамжуулан суралцах нь* сэдэвт өгүүллийг Дэб Биалески, Стефен Файн, Трой Беннет нар нийтэлсэн. Тус нийтлэлд гадна орчноор дамжуулан суралцахад чиглэсэн олон улсын судалгаа шинжилгээний голлох бүтээлүүдээс жишээ авч зуслангийн талаар мэдлэг, туршлагуудыг илрүүлэх зорилгыг агуулсан байна. КЗХ-ны судалгаа шинжилгээний цахим хуудаснаас http://www.ccamping.org/research/research-papers/ тус нийтлэлтэй танилцах боломжтой.

Тусгай хөтөлбөр, хурал

АНУ: өмнөх жилүүдэд зохион байгуулагдсан АНУ-ын Зуслангуудын Холбооны Үндэсний Бага Хурлын үеэр ОУЗХ нь орон нутгийн зуслангууд болон олон улсын амрагчдад зориулсан өсвөр залуу үеийнхний хөтөлбөрүүдийг зохион байгуулан өсвөр залуу үеийнхэнд зориулсан үйл ажиллагаануудыг танилцуулж бусад зуслангуудын боловсон хүчин, мэргэжлийн хүмүүстэй уулзаж танилцах боломжийг олгодог. 2017 онд 37 зочдыг хамруулсан аяллыг **Линда Пюлиам** (Linda Pulliam), доктор **Гвин Паул** (Gwynn Powell) нар зохион байгуулж Шинэ Мексикийн Албукүркийн зуслангуудад зочилж өсвөр залуу үеийнхэнд зориулсан хөтөлбөрүүдтэй танилцсан. Тус аяллын анхны алхамыг эхлүүлэхээр **Жим Кейн** (Jim Cain) танилцах өдөрлөгийг зохион байгуулах ажлыг дэмжиж ажилласан.

Ази-Номхон далайн орнуудын Зуслангуудын Холбоо
Азийн Олон Улсын Зуслангуудын Холбоо боллоо

2016 оны 10-р сард Япон улсын Токио хотод зохион байгуулагдсан Ази Номхон Далайн Орнуудын Зуслангуудын Холбооны 6 дахь удаагийн Их хурлын үеэр тус чуулганы гишүүд зөвлөлдөж Ази Номхон Далайн Орнуудын Зулсангуудын Холбоо нь олонхийн саналаар Олон Улсын Зуслангуудын Холбооноос өрх тусгаарлаж бие даасан холбоо болсон. Тус хоёр холбоодын Удирдах Зөвлөлийн гишүүдийн хэлэлцэж тус шийдвэрийг гаргасан юм.

Зүүн Ази дахь зуслангуудын харилцаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэн дэмжих зорилгоор 2003 онд Мельбурн хотод зохион байгуулсан ОУЗХн-ны ээлжит Их хурлын үеэр Ази Номхон Далайн Орнуудын Зуслангуудын Холбоог анх үүсгэн байгуулжээ. Тухайн үед цахим харилцаа холбоо хөгжлийнхөө анхан шатанд байсан бөгөөд ОУЗХ-ноос хүрч ажиллаж чадахгүй нөхцөлд энэ үүргийг бүс нутгийн байнгын холбоо гүйцэтгэж чадна гэж үзэж байсан юм. Бас нэгэн хэтийн зорилго бол ОУЗХ-ны олон улсын зуслангууд нүүр тулан уулзаж мэргэжилтэн хөгжүүлэх талаар хэлэлцэх боломжийг олгох явдал юм.

Энэ зорилгын хүрээнд АНДОЗХ-г амжилттай үүсгэн байгуулсан. Тус холбооны чуулганыг Монгол, Малайз, Тайван, Хон Конг, Австрали, Япон улсуудад зохион байгуулсан. АНДОЗХ-г татан буулгах шийдвэр гаргахад нөлөөлсөн хүчин зүйл бол ОУЗХ нь бүс нутгийн зуслангуудын чуулганд үзүүлдэг дэмжлэгийг үргэлжүүлнэ гэсэн итгэл байсан.

Ази дахь ОУЗХ-ны гишүүд орчин үед олон нийтийн мэдээлийн хэрэгсэл, цахим шуудан, ОУЗХ-ны цахим сүлжээ гэх зэрэг цахим харилцаа холбоог өргөнөөр ашиглах болсон билээ. Азийн ОУЗХ нь зуслангуудын харилцаа холбоог идэвхжүүлэгч, бүс нутаг дахь зуслангуудын өсөлтийг урьд өмнөхтэй адил эрч хүчтэй үргэлжлүүлэгч байх ба гэхдээ эдгээр хоёр “Холбоод”-ын хооронд хольж төөрөгдөх хэрэггүй юм.

ОУЗХ нь Бүс Нутгийн Зуслангийн Их хурлын загварыг боловсруулан гаргасан бөгөөд одоогийн байдлаар Ази Номхон Далайн Орнуудын Зуслангуудын Холбооны 7 дахь Их хурлыг зохион байгуулахаар Малайз дахь тус чуулганыг зохион байгуулах хороотой хамтран ажиллаж байна.

Билл Боукер Сан, Баттерфлай Сан

Билл Боукер сангийн зорилго нь ОУЗХ-ны Их хурал, ОУЗХ-ны бүс нутгийн хурал, тэмдэглэлт үйл явдал, ОУЗЗСургалт болон ОУЗХ-ноос зохион байгуулдаг бусад сургалтууд мөн ОУЗХ-ны Удирдах Зөвлөлөөс гаргасан ОУЗХ-ны хэтийн зорилго, зорилтуудад багтсан гадаад үйл ажиллагаанд зуслангийн боловсон хүчин, мэргэжилтнүүдийг татан оролцуулахад дэмжлэг үзүүлэхэд оршдог. Тус сангаас гаргаж буй санхжүүжилтийн хувиарлалтыг батлах хороо нь Санхүүгийн албаны дарга, Ерөнхийлөгч,

Сангийн хуваарилалтыг батлах хороо одоогийн Женни Боукер нараас бүрддэг.

ОУЗХ-ны Удирдах Зөвлөл нь нэг болон түүнээс дээш хувь хүмүүст зориулсан үндэсний болон бүс нутгийн холбоонд тэтгэлэгээр туслалцаа үзүүлэх, холбогдох хүмүүсийг сонгохын тулд тухайн холбоод хариуцлага хүлээлгэж болно. 2017 оны ОУЗХ-ны Их хурлын үеэр Перу, Канад болон өмнөд Солонгосын нэр дэвшигчдэд тэтгэлэг олгосон. Түүнчлэн Токио хотноо зохион байгуулагдсан АНДОЗК-ийн Их хуралд оролцсон Перу, Нигер улсуудын төлөөлөгчдөд тусламж, дэмжлэг үзүүлсэн.

Баттерфлай (Эрвээхэй) Сан нь тодорхой хувь нэмэр оруулсан ОУЗХ-ны гишүүд болон бусад төлөөлөгчидэд зориулсан тусдаа сан бөгөөд Билл Боукер Санд хамрагдаж чадаагүй Олон Улсын Зуслангийн Холбооны онцгой төслүүдэд тэтгэлг олгодог.

ОУЗХ-ны Удирдлагын бүтэц

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА					
			Ерөнхийлөгч Жон Йоргенсон (John Jorgenson)		
			ОУЗХ-г бүрэн төлөөлнө.		
			Удирдах зөвлөлийн хурал, ээлжит болон ээлжит бус хурлыг удирдан явуулна.		
			Гүйцэтгэх удирдлагын хорооны хэлэлцүүлгийг удирдана.		
			Шаардлагатай тохиолдолд Зөвлөх Зөвлөлийн гишүүдтэй хамтран ажиллана.		
	Өмнөх Ерөнхийлөгч Валери Костин	**Шинээр сонгогдсон Ерөнхийлөгч**	**Дэд Ерөнхийлөгч Фахреттин Гозет**	**Ерөнхий нарийн бичгийн дарга Марко Рейс**	**Санхүүгийн алба Жилл Дандас**
	Шаардлагатай үед холбооны Ерөнхийлөгч болон Удирдах зөвлөлд зөвлөгөө өгнө	Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас бүтэн нэг жилийн өмнө сонгогдоно.	Удирдах зөвлөлийн зарим гишүүдийн нэмэлт хариуцлагыг хүлээнэ.	Хурлын тэмдэглэл хөтөлж ирүүлэх.	Холбооны санхүүтэй холбоотой бүх ажлыг хянан зохицуулна.
	Гүйцэтгэх удирдлага, Удирдах зөвлөлийн бүх хуралд оролцоно.	Гүйцэтгэх удирдлага, Удирдах зөвлөлийн бүх хурал оролцоно.	Удирдах зөвлөлийн одоо байгаа гишүүдээс сонгогдох буюу томилогдоно.	Удирдлагаас өгсөн бүх ажил, үүргийг хянан зохицуулна.	Жилийн эцсийн тайланд оруулах санхүүгийн тайланг боловсруулна.
	Зөвлөх Зөвлөлд багтана. (санал өгөх эрхгүй)	Зөвлөх Зөвлөлд багтана. (санал өгөх эрхгүй)	Гүйцэтгэх удирдлагын хорооны гишүүний хувиар оролцоно.	Шаардлагатай үед Гүйцэтгэх удирдлагын хорооны хэлэлцүүлэгт оролцоно.	Шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэх удирдлагын хорооны хэлэлцүүлэгт оролцоно.
			Ерөнхийлөгчийг орлоно.	Удирдах зөвлөлд танилцуулах Жилийн эцсийн тайланг боловсруулж ирүүлнэ.	Санхүүгийн зөвлөмж өгөх шаардлагатай үед зөвлөлд багтана.

УДИРДАХ ЗӨВЛӨЛ						
	Мэдээлэл харилцааны алба Панваса Кейт Смит	**Бүрэн эрхт гишүүн Линда Пуллиам**	**Гишүүнчлэлийн алба Алексиа Сидери**	**Бүрэн эрхт гишүүн Анна Маргрет Томасдоттир**	**Ерөнхий элч Пабло Казас Алатристе**	**Бүрэн эрхт гишүүн Масако Харигаяа**
	Цахим хуудас	Удирдах зөвлөлийн хуралд идэвхитэй оролцоно.	Гишүүнчлэлийн бүртгэл	Удирдах зөвлөлийн хуралд идэвхтэй оролцоно.	Их хурлын Ерөнхий Ассемблейн	Удирдах зөвлөлийн хуралд идэвхтэй оролцох
	Интернет-сонин	Бүс нутгийн тэнцвэртэй байдал болон соёлын төлөв байдлыг хариуцаж ажиллана.	Гишүүдэд үзүүлэх үйлчилгээ	Бүс нутгийн тэнцвэртэй байдал болон соёлын төлөв байдлыг хариуцаж ажиллана.	Элчийн харилцаа холбоо	Бүс нутгийн тэнцвэртэй байдал болон соёлын төлөв байдлыг хариуцаж ажиллана.
	Цахим нийтлэл, хэвлэл, мэдээлэл	Тусгай ажлын хэсэг, төсөл хөтөлбөрийг хариуцна.	Харилцаа холбооны зохицуулалт	Тусгай ажлын хэсэг, төсөл хөтөлбөрийг хариуцна.	Холбооны харилцаа холбоо	Тусгай ажлын хэсэг, төсөл хөтөлбөрийг хариуцна.
	ОУЗЗСургалтын хяналт Эндрю МакГукиан	**Бүрэн эрхт гишүүн Алексей Андреев**	**Хөтөлбөр боловсруулалт Жефф Брадшо**	**Их хуралд тавих хяналт Фахреттин Гозет**	**Хөгжлийн асуудал Гонзало Велоз**	
	ОУЗЗСургалтын харилцаа холбооны талаар Конние Кютеллиер	Удирдах зөвлөлийн хуралд идэвхтэй оролцох	Шагнал урамшуулал	Тендерийн зохицуулалт	Брэнд	
	Сургалтын хөтөлбөр боловсруулалт	Бүс нутгийн тэнцвэртэй байдал болон соёлын төлөв байдлыг хариуцаж ажиллана.	Судалгаа шинжилгээний хороонд хандах	Дараагийн Их хурлын харилцаа холбоо	Стратегийн түншлэл	
	ОУЗЗСургалтын Архив, Бүртгэл	Тусгай ажлын хэсэг, төсөл хөтөлбөрийг хариуцна.	Тусгай Төсөл, Хөтөлбөрүүд	Бүс нутгийн Их хуралтай нягт харилцаа холбоотой ажиллах	ОУЗХ-ны Цахим сүлжээ	

ЗӨВЛӨХ					
	Зөвлөх Зөвлөл	**Дотоод түнш хариуцсан алба**	**Элч нарын алба (Ерөнхий Ассемблей)**	**Гадаад түнш хариуцсан алба**	**Холбоонй сүлжээ хариуцсан алба**
	Удирдах хороо/Удирдах зөвлөлийн өмнөх бүх гишүүд	ОУЗХ-ны дэд бүлгүүд, тусгай ашиг сонирхолын группууд болон дэд байгууллагууд	Ерөнхий ассемблей чуулганы үеэр Гүйцэтгэх удирдлагын хороо болон Удирдах зөвлөлтэй нягт уялдаа холбоотой ажиллана. Удирдах зөвлөлийн тэнцвэртэй байдлыг хангах үүднээс Ерөнхий ассемблейн чуулганы үеээр Удирдах зөвлөлийн 3 гишүүнийг Элч нар сонгоно. Элч нар нь Их хурлын Ерөнхий ассемблейн үеэр хуран чуулж Удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд зөвлөмж, чиглэл хүргүүлнэ.	Олон улсын бусад зуслангууд	Гишүүнчлэлтэй холбоодын Ерөнхийлөгч нар болон Гүйцэтгэх удирдлагууд
	Хүндэт гишүүд	Гүйцэтгэх удирдлагын хороотой нягт уялдаа холбоотой ажиллах		Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг гишүүнчлэлгүй байгууллагууд	Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх удирдлагын хороотой харилцаа холбоотой ажиллах
	Гүйцэтгэх удирдлагын хороотой нягт уялдаа холбоотой ажиллах			Гүйцэтгэх удирдлагын хороотой нягт уялдаа холбоотой ажиллах	Шаардлагатай үед Их хурлын үеэр Тусгай хурал чуулган зохион байгуулах

ОУЗХ-ын Удирдах Зөвлөл 2017-2020

Жон Йоргенсон

Ерөнхийлөгч

Валерий Костин

Өмнөх Ерөнхийлөгч

Фахреттин Гозет

Дэд Ерөнхийлөгч

Марко Рейс

Ерөнхий Нарийн Бичгийн Дарга

Жилл Дандас

Санхүүгийн Албаны Дарга

Панваса Кейт Смит

Мэдээлэл, Харилцаа, Холбоо хариуцсан алба

Пабло Казас Алатристе

Элчийн харилцаа холбоо хариуцсан алба

Гонзало Велоз

Бизнес Хөгжил хариуцсан алба

Алексей Сидери

Гишүүнчлэл хариуцсан алба

Жефф Брадшо

Хөтөлбөр боловсруулалт

Эндрю МакГукиан

ОУЗЗСургалт

Линда Пуллиам

Бүрэн Эрхт Гишүүн

Анна Маргрет Томасдоттир

Бүрэн Эрхт Гишүүн

Масако Харигаяа

Бүрэн Эрхт Гишүүн

Алексей Андреев

Бүрэн Эрхт Гишүүн

Хүндэт гишүүд

Арманд Бол

Женни Бөүкер

Дик Чамберлайн

Сачико (Сако) Танака

Жак Пиерс* (нас барсан)

Олон Улсын Зуслангуудын Холбооны талаар дэлгэрэнгүй мэдээллийг www.campingfellowship.org цахим хуудаснаас авах боломжтой.

ОУЗХ-ны үйл ажиллагааг идэвхтэй дэмжигч сайн дурын ажилтан болохыг хүсвэл volunteer@campingfellowship.org цахим хаягаар бидэнтэй холбогдоно уу!

www.campingfellowship.org